

I-V ангийн унших чадварын агуулгын залгамж холбоо

Анги	1-р анги	2-р анги	3-р анги	4-р анги	5-р анги
УНШИХ ЧАДВАР					
Унших чадварт тавигдах шаардлага уншлагын чанар	Зөв унших	Унших хурдаа нэмж, бусдад ойлгогдохоор зөв, унших	Өгсөн эхийг бусдын дэмжлэгтэй, ойлгож унших	Ойлгон уншиж, уншсанаа бусадтай хуваалцан ярилцах	Ойлгон уншиж, уншсанаа бусадтай хуваалцан ярилцах
Эхийн агуулгыг ойлгосноо харуулах	1.1.а. Өгүүлбэр, эхээс танил биш үгийг олж, утгыг нь таамаглах	2.1.а. Танил биш үгийг сурах бичгийн тайлбараас цагаан толгойн үсгийн дарааллаар үгээ сонгох, утгыг мэдэх	3.1а. Уншсан эх дэх танил биш үгийг тайлбар толь бичгээс үсгийн дарааллаар олж, агуулгыг ойлгох	4.1а. Уншсан эх дэх танил биш үгийг тайлбар толь бичгээс олж, агуулгыг ойлгох	5.1а. Эхэд ашигласан зарим үг, хэллэгийг сонгож, эхэд хэрэглэсний учрыг тайлбарлан дүгнэх
	1.1.б. Сурах бичгийн эх, зурагт эх, богино хэмжээтэй хялбар эхийг уншиж агуулгыг ерөнхийд нь ойлгосноо харуулах	2.1б. Уншсан шүлэг, өгүүллэг, үлгэр, зүйр цэцэн үг зэрэг эхийг уншиж, агуулгыг ерөнхийд нь ойлгосноо харуулах	3.1б. Уншсан эх, үлгэр, өгүүллэг, шүлгээс чухал хэсгийг ялгаж, ойлгосноо харуулах	4.1б Уншсан эхийн болон үлгэр, өгүүллэгийн бүтцийн холбоо хамаарлаас гол санааг ойлгосноо харуулах	"5.1.б. Нэг сэдэвтэй хоёр эхийн утгыг харьцуулах замаар эхийн агуулгыг ойлгосноо харуулах 5.1.в.Уншсан жүжгийн гол санааг тайлбарлах"
	1.1.в. Уншсан эхийн үйл явдлыг асуултын дагуу тоочих (эхлээд? дараа нь, эцэст нь?)	2.1.в. Уншсан үлгэр, өгүүллэгийн үйл явдлыг дарааллын дагуу тоочих	3.1в. Уншсан үлгэр, өгүүллэг дэх баатрын үйл хөдлөлийн учир шалтгааныг тайлбарлах	4.1в. Уншсан эх, үлгэр, өгүүллэгийн бүтцийн хэсгүүдийн учир шалтгааныг тайлбарлах	5.1.г. Уншсан эхийн эхлэл, гол, төгсгөл хэсгүүдийн утгын холбоо хамаарлыг тайлбарлах
				4.1г Шүлэг дэх хоёр зүйлийн ижил төстэй шинжийг харьцуулан адилтган дүрслэлийг тайлбарлах	5.1.д. Эхээс хүншүүлсэн, хэтрүүлсэн дүрслэлийг тайлбарлах замаар үлгэрийн утгыг ойлгосноо харуулах
			3.1г. Эхээс баатрын болон зохиогчийн үгийг ялгах	4.1д. Эхэд ашигласан баримт ба өгүүлэгчийн үзэл бодлыг илэрхийлсэн хэсгийг ялгах	5.1.е. Үлгэрт амьдралын бодит байдлыг тусгасан эс тусгасан шинжээр нь бодит байдал ба уран сэтгэмжийг ялгах
	"1.1.г. Уншсан эхийн баатрын хийсэн зүйлийг тоочих "	2.1.г. Уншсан эхийн баатруудын сайн, муу үйлийг жишээгээр тайлбарлах	3.1д. Уншсан зохиолын баатруудын зан чанарыг эхээс жишээ татаж тайлбарлах	4.1е. Эхийн эхлэл, гол, төгсгөл хэсэгт баатруудын зан чанар, үзэл бодлод гар-сан өөрчлөлтийг харьцуулах	5.1.ж. Уншсан эхийн баатруудын харилцан ярианаас тэдний зан чанарыг дүгнэх
		2.1.д. Талархал, мэндчилгээ, товч янкет, гэр бүлийн танилцуулга, заавар зэргийг уншиж, агуулга, бүтцийг тайлбарлах	3.1е. Талархсан захидал, зорилгодоо хүрэх төлөвлөгөө, номын тэмдэглэл, хаяг, шошго зэргийг уншиж, агуулга, бүтцийг тайлбарлах	4.1ж. Урилга, уриалга, номын танилцуулга, сонины мэдээ, талархлын захидал зэргийн зорилго, бүтцийг тайлбарлах	5.1з. Захидлаас нэг сэдвийн талаар ялгаатай үзэл бодлыг харьцуулж дүгнэх
	1.1.д. Цээжилсэн хэл зүгш-рүүлэх үг, балгэ дэмбэрлийн үг, шүлгийг бусдын өмнө тод чанга дуугаар унших	2.1.е. Цээжилсэн шүлэг, зугаа үг, хэл зүгшрүүлэх үгийг бусдын өмнө тод чанга дуугаар унших	3.1ж. Цээжилсэн шүлгийн утгыг мэдэрч, мэдрэмжээ илэрхийлэн уран унших	4.1з. Хурд, дууны өнгөө тохируулан урнаар уншиж, шүлгийн утгыг ойлгосноо харуулах	"5.1и. Зохиолчийн санааг мэдэрч, уран унших
Бүтээлчээр ойлгож унших	1.1.е. Зохиолын баатруудын гадаад байдлыг төсөөлөх	2.1.ж. Өгсөн зургаас баатрууд хоорондоо юу ярилцсаныг ургуулан төсөөлөх	"3.1з. Үлгэр, өгүүллэгийн үйл явдлыг уншихдаа гол баатрын хэлэх үгийг ургуулан бодож, төсөөлөх"	"4.1и. Зохиолын баатрын гадаад дүр байдлыг ургуулан бодож төсөөлөх"	5.1к. . Үйл явдал хаана, хэзээ өрнөж байгааг ургуулан бодож төсөөлөх
		2.1.з. Өгсөн зургаас үндэслэн үйл явдлыг таамаглах	3.1и. Уншсан үлгэр, өгүүллэгийн гол хэсгийн үйл явдлыг хэрхэн өрнөхийг таамаглах	4.1к. Эхийн үйл явдлын төгсгөлийг үндэслэлтэйгээр таамаглах	5.1л. Оньсогын далд утгыг үндэслэлтэй таамаглах

2.1д суралцахуйн зорилтын хүрээнд боловсруулагдсан хэрэглээний эхийн бүтэц, агуулгыг уншиж ойлгох ажлын хуудас нь тухайн хэрэглээний эх бичихийн хамгийн эхний ажлын хуудас болон бичихэд орсон байгаа. Жишээлбэл: Талархал бичих 2.2з зорилтын ажлын хуудасны хамгийн эхэнд талархлын бүтэц, агуулгыг ойлгох 2.1д зорилтын ажлын хуудсыг ажиллана. Бусад хэрэглээний эх мөн адил явна.



Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр.....цаг



Эхийн агуулгыг эхлээд юу болов?, дараа нь яав?, эцэст нь юу болсон бэ? гэсэн асуултуудын дагуу үйл явдлын дарааллыг тоочно.

1 Эхийг анхааралтай уншаад, зургийг зөв дарааллаар дугаарлаарай.

ЦАСАН ХҮН

Цаг агаар хүйтэрч цасан шуурга болжээ. Хүүхдүүд цонхоор харвал гадаа шинэхэн орсон цас ихээр овоорсон байв.

Анар, Тэнүүн хоёр шинэхэн тогтсон цасаар цасан хүн хийж өдөржин тоглов. Тэд амралтынхаа өдрөөр цасан хүнээ харахаар очдог байлаа. Нэг удаа тэднийг эргэж очиход цасан хүн бүр жижгэрчихсэн байв. Яагаад жижгэрсэн учрыг тэд ойлгосонгүй. Эмтэрч гэмтсэнийг нь засаж янзлаад эргэж байхаар ярилцаад буцав.

Хэд хоногийн дараа тэднийг эргэж очиход, цасан хүн нь хайлаад урсчихсан байжээ.









2 Уншаад асуултын дагуу тохирох хэсгийг хайчлаад наагаарай.

1. Эхлээд юу болов?

2. Дараа нь юу болов?

3. Тэгээд яасан бэ?

4. Тэгээд юу болов?

5. Эцэст нь юу болов?

Дууссан:.....онсарөдөр..... цаг

Өөрийн үнэлгээ:

1 2



Эмтэрч гэмтсэнийг нь засаж янзлаад буцав.

Бид овоорсон шинэхэн цасаар цасан хүн хийж өдөржин тоглов.

Цасан хүнээ эргэж очиход бүр жижгэрчихсэн байв.

Цасан хүн хайлсаар байгаад урсаад явчихсан байв.

Яагаад жижгэрсэн учрыг тэд ойлгосонгүй.



Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр.....цаг



- Эхийн агуулгыг эхлээд юу болов?, дараа нь яав?, эцэст нь юу болсон бэ? гэсэн асуултуудын дагуу үйл явдлын дарааллыг тоочно.

1 Эхийг анхааралтай, ойлгож уншаарай.

Ах дүү хоёр бамбарууш

Модны сүүдэрт хоёр бамбарууш сууж байлаа. Ах бамбарууш нь дүү бамбаруушдаа жимс олж идье гэж хэлэв. Гэтэл дүү нь тэр модны мөчир дээр байгаа зөгийн үүрнээс зөгийн бал авъя гэж зөржээ.

Ах нь зөгийд хатгуулснаас жимс түүж идсэн нь дээр гэв. Гэтэл дүү нь зөвшөөрсөнгүй тул ах бамбарууш ганцаараа ой уруу жимсэнд явлаа. Бидний хэн нь их юм олж идэх бол доо! хэмээн дүү бамбарууш зөгийний үүр лүү зүтгэв. Балнаас идэх гэж байтал бөөн зөгийнүүд нисэн ирж хатгаж гарав. Бамбарууш арай гэж зугтаж аврагдаад, цааш ахыгаа хайн гунигтай алхав.


Ах нь дүүгээ хараад, зөгийнүүд чамайг танихын аргагүй болгож дээ. Ах нь сайхан амттай жимс цадталаа идлээ. Ахынхаа үгэнд орсон бол ингэхгүй л байсан юм гэлээ.

2 Асуултын дагуу үйл явдлын дарааллыг ойлгож, давтан уншилт хийгээрэй.





2 Цэгийн оронд тохирох үгийг нөхөөрэй.



1. Ах нь дүүдээ ой уруу явж жимс олж идье гэв.



2. Гэтэл дүү нь зөвшөөрсөнгүй, зэгийн үүрнээс авья гэв.



3. Ах нь ой уруу явж, харин дүү нь зүтгэв.



6. Ах нь хараад, ахынхаа орсон бол ингэхгүй л байсан юм гэв.



5. Дүү бамбарууш зэгийнөөс арай гэж зугтаад, цаашОЧИВ.



4. Зэгийн балнаас идэх гэж байтал хатгуулав.

3 Цэгийн оронд тохирох үгийг нөхөөрэй.

- а. Ах бамбарууш ньидэхээр уруу явсан.
- б. Дүү бамбарууш нь идэхээрлүү зүтгэв.

4 Асуултад хариулаарай.

- а. Хоёр бамбаруушийн хэнийх нь шийдвэр зөв байсан бэ?
 Жимс идсэн ахын зөв Зэгийн бал идсэн дүүгийн зөв

б. Дүү бамбарууш ахыгаа хайж гунигтай алхахдаа юу бодсон бол?

.....

.....

.....

в. Хэрэв ахынхаа үгэнд орсон бол яах байсан бол?

.....

.....


.....



Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр цаг

Сохор хүн

/Унгар ардын үлгэр/



Шөнө дунд нэгэн сохор хүн явж байв. Тэр нэг гартаа дэнлүү, нөгөө гартаа ваар барьж явав. Хүмүүс түүнийг шоолж: - Сохор минь, чамд дэнлүү ямар хэрэгтэй юм бэ? гэж асуужээ. Сохор хариуд нь: - Дэнлүүг өөртөө бус та нарт зориулсан юм. Яагаад гэвэл та нар харанхуйд намайг харалгүй мөргөөд, ваарыг минь хагалчихна шүү дээ гэж гэнэ.

1 Дараах өгүүлбэрүүдийг уншаад зөв дараалалд оруулж дугаарлаарай.

. Хүмүүс түүнийг “Сохор байж гэрлээр яах нь вэ?” гэж шоолсон.

4 Гэтэл сохор дэнлүүг өөртөө бус тэдэнд зориулж замыг гэрэлтүүлсэн.

. Тэр нэг гартаа дэнлүү, нөгөө гартаа ваар барьж явав.

. Шөнө нэгэн сохор хүн явж байсан.

. Учир нь хүмүүс сохор хүнийг мөргөчихвөл түүний ваарыг хагална.

2 Хүмүүс яагаад түүнийг шоолсон бэ?

3 Сохор хүн дэнлүү барьж явсан нь зөв үү? Буруу юу? Яагаад?

4 Сохор хүн ямар хүн бэ? Будаарай.

сайхан сэтгэлтэй	ухаантай	бусдын төлөө
алсын бодолтой	тэнэг	хувиа хичээсэн

5 Чи үлгэрээс юу ойлгож ухаарч авснаа бичээрэй.